

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



САХИЛГА, ХАРИУЦЛАГА ТООЦОХ БАЙГУУЛЛАГЫН
ДАРГА, НЯГТЛАН БОДОГЧ

Д/д	Сум	Байгууллагын нэр	Дарга, эрхлэгч	Нягтлан бодогч
1	Баруунбаян-Улаан	Төрийн сангийн нэгдсэн тайлан	Д.Баатарчулуун	Э.Даваасүрэн
2	Баруунбаян-Улаан	Ерөнхий боловсролын сургууль	Д.Загарзүсэм	Т.Цэцэгмаа
3	Нарийнтээл	Ерөнхий боловсролын сургууль	Б.Түмэндэмбэрэл	О.Насандулам
4	Сант	Төрийн сангийн нэгдсэн тайлан	С.Дамдинпүрэв	М.Отгонбат
5		Өв Эко мийт ОНӨААНэгж	П.Загарзүсэм	Б.Мөнхбадрал



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/ЗЧЧ

Арвайхээр

Г Хариуцлага тооцох, шагнал, урамшуулал Г
олгох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2013 оны а/406 дугаар захирамжаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарын ажлын үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны төсөв санхүүгийн сахилга бат, хариуцлага, санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг үндэслэн төсвийн захирагч, Санхүүгийн албаны дарга нарын урамшууллын хэмжээг нэгдүгээр, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон орон нутгийн төсвийн байгууллагын дарга, нягтлан бодогч нарын урамшууллын хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Захирамжийн 1, 2 дугаар хавсралтаар олгох урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс олгохыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

3. Хяналт, шалгалтын байгууллага болон санхүүгийн аудитын дүгнэлтээр зөрчилтэй гарч “Хязгаарлалттай” дүгнэлттэй гарсан байгууллагуудын төсвийн захирагч болон нягтлан бодогч нарт “Сануулах” арга хэмжээ тооцохыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

4. Уг захирамжийн гуравдугаар хавсралтаар хариуцлага тооцсон болон урамшуулал тооцсон албан тушаалтнуудаас бусад сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны мэргэжилтэн, нягтлан бодогчид, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарыг санхүүгийн тайлангийн дүгнэлт болон гарсан алдаа зөрчил, ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгох, хариуцлага тооцож хариу мэдэгдэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр), төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100527